Батлав.

Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор

Б.Даваасүрэн

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХИЧЭЭЛИЙН 3-Р БАЙРНЫ ЛЕКЦИЙН ТАНХИМЫН ТАВИЛГЫН ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026.11.13


Ерөнхий мэдээлэл	• Шинээр баригдах барилгын 5 лекцийн заал тус бүрд модон ширээ сандлын иж бүрдлийн загвар, ажлын зураг боловсруулах, • Техникийн хэсэг буюу синхрон орчуулгын зориулалтын акустик бүхий шилэн бүхээгийн ажлын зураг боловсруулах
Зориулалт:	Лекц, сургалт, хурал, семинар зохион байгуулах
Захиалагч байгууллага:	Монгол Улсын Их Сургууль
Зургийн ажлын зорилго:	Лекцийн заалны архитектур, интерьерийн ерөнхий шийдэлтэй уялдуулан орчин үеийн загвар хийцтэй, ашиглалтын шаардлага хангасан модон ширээ, сандлын иж бүрдлийн загвар гаргаж, үйлдвэрлэл, угсралтад ашиглах нарийвчилсан ажлын зураг, мөн техникийн хэсэг буюу синхрон орчуулгын зориулалтын шилэн бүхээгийн ажлын зураг боловсруулахад оршино.
Ажлын байршил, цар хүрээ:	УБ хот, СБД VI хороо, МУИС-ийн хичээлийн 3-р байрны “А” блок 5, 6 дугаар давхарт • МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 3”А” байрны 6 давхарт байрлах 133 хүний суудал бүхий ширээ, сандал, тайз хэсгийн ширээ, сандал, техникийн хэсэг байрлах шилэн кабин (техник, синхрон орчуулгын төхөөрөмж байрлах) танхимын тавилгын зураг гаргах • МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 3”А” байрны 6 давхарт байрлах 160 хүний суудал бүхий ширээ, сандал, тайз хэсгийн ширээ, сандал, техникийн хэсэг байрлах шилэн кабин (техник, синхрон орчуулгын төхөөрөмж байрлах) танхимын тавилгын зураг гаргах • МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 3”А” байрны 6 давхарт байрлах тус бүр нь 80 хүний суудал бүхий ширээ, сандал, тайз хэсгийн ширээ, сандал (уг сандал, ширээ нь

	шаланд тогтоохгүй, хөдөлгөж болох хөнгөн жинтэй боловч даац сайтай байх) бүхий 2 танхимын тавилгын зураг гаргах • МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 3"А" байрны 5 давхарт байрлах 72 хүний суудал бүхий ширээ, сандал, тайз хэсгийн ширээ, сандал, техникийн хэсэг байрлах шилэн кабин (техник, синхрон орчуулгын төхөөрөмж байрлах) лекцийн танхимын тавилгын зураг гаргах
Зураг төсөлд тавигдах үндсэн шаардлага	**Ширээ сандал, индрийн хэсгийн тавилга:** 1. Ширээ сандлын загвар нь лекцийн заалны архитектур, интерьерийн өнгө төрхтэй нийцсэн байна. 2. Байгалийн модон материал болон чанартай модон хавтан ашигласан бат бөх, эдэлгээ даах хийцтэй байна. 3. Ширээ сандал нь хүний биеийн онцлог, тав тух, эргономикийн шаардлагад нийцсэн байна. 4. Ширээний тавцан нь бичих, ном, компьютер болон сургалтын материал байрлуулахад тохиромжтой байна 5. Сандлын түшлэг, суудлын өндөр, налуу" нь удаан хугацаагаар сууж лекц сонсоход тав тухтай байна. 6. Материалын өнгө, гадаргуугийн боловсруулалт нь элэгдэл, зураас, чийгийн нөлөөнд тэсвэртэй байна. 7. Ширээ сандлын ирмэг, буланг аюулгүй байдлыг хангахуйц боловсруулсан байна. 8. Цэвэрлэгээ, арчилгаа хийхэд хялбар, эд анги солих, засвар үйлчилгээ хийх боломжтой байна. **Техникийн хэсэг буюу синхрон орчуулгын зориулалтын шилэн бүхээг:** 1. Шилэн бүхээгийн дотор талбайг тухайн орчинд тохируулан, тоног төхөөрөмжийн байрлал болон эргономикийн дагуу боловсруулах 2. Заалны дэлгэц, илтгэгчийг харах харагдацтай байх

	3. Орчуулгын тоног төхөөрөмжийг заалны дууны системтэй холбох 4. Орчуулгын дуут сонсогчдод утасгүй чихэвчээр дамжуулах боломжтой байх 5. Агааржуулалт, дуу тусгаарлалтыг тусгайлан тооцох 6. Бүхээгт цахилгаан розетка, тоног төхөөрөмжийн холболтын цэг төлөвлөх
Зураг төсөлд тусгах зүйлс:	• Лекцийн заалны тавилгын ерөнхий төлөвлөлт, хөндлөн огтлолын зураг • Ширээний ерөнхий загвар, нүүр, хажуу, арын харагдац, • Сандлын ерөнхий загвар, нүүр, хажуу, арын харагдац • Ширээ, сандлын хэмжээст зураг • Техникийн хэсэг буюу синхрон орчуулгын зориулалтын шилэн бүхээгийн байрлал • Материалын сонголт, өнгө, гадаргуугийн боловсруулалт • Холболт, бэхэлгээ, угсралтын нарийвчилсан зураг • Тавилгын материал, эд ангийн дэлгэрэнгүй тодорхойлолт • Ширээ сандлын 3D загвар, өнгөт дүрслэл • Үйлдвэрлэл, угсралтын ажлын зураг
Материал, хийцийн шаардлага	• Ширээний тавцан: байгалийн модон өнгөлгөөтэй хавтан эсвэл чанарын шаардлага хангасан ус чийгийн хамгаалалттай, меламин өнгөлгөөтэй, E1 ангиллын стандарттай модон материал • Ширээ сандлын үндсэн хийц: хатуу модон материал эсвэл бат бэх модон хийцтэй, булан ирмэг нь зориулалтын материалаар хүрээлсэн байх • Сандалын түшлэг болон суудлын хэсэг нь даац сайтай, нимгэн зөөлөвч бүхий модон материалтай, суудал хэсэг хойшоо эвхэгддэг байх • Гадаргуугийн өнгөлгөө: элэгдэлд тэсвэртэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй лак будаг • Бэхэлгээ, холболт: бат бөх, далд холболтын шийдэлтэй байх • Шилэн бүхээг нь тусгаарлалтын ханын зориулалттай, зузаан матт хуулгатай байх • Өнгө материалын сонголтыг захиалагчтай зөвшилцөж баталгаажуулна.
Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	**Захиалагчаас**: 1. Лекцийн заалны архитектурын ажлын зураг 2. Өрөөний хэмжээ, талбайн мэдээлэл

	3. Интерьерийн өнгө, материалын шийдэл 4. Ширээ, сандлын тоо хэмжээ, суудлын багтаамж 5. Захиалагчийн санал, шаардлага
Зураг төсөл гүйцэтгэгчийн бүрдүүлэх материал	1. Загварын концепц, өнгөний шийдэл 2. 3D өнгөт дүрслэл 3. Ширээ, сандлын хэмжээст ажлын зураг 4. Материалын түүвэр, техникийн тодорхойлолт 5. Холболт, угсралтын дэлгэрэнгүй зураг 6. Тоо хэмжээ, материалын жагсаалт 7. Үйлдвэрлэлд шилжүүлэх иж бүрэн ажлын зураг Тухайн танхимын хэмжээнээс хамаарч индрийн ширээ, индрийн ширээний сандал 3 ширхэг болон танхимд багтах боломжит ширээ, сандлын тоог эцэслэн тодорхойлох
Зураг төслийг баталгаажуулах	Зураг төсөл боловсруулагч нь ширээ, сандлын загвар, өнгө, материалын сонголт, хэмжээ, хийцийн шийдлийг захиалагчид танилцуулж, санал авч эцэслэн баталгаажуулсны дараа үйлдвэрлэлийн ажлын зургийг боловсруулна.

Хянасан: Хангамж, үйлчилгээний газрын дарга Б.Шижиржаргал /...../

Боловсруулсан: Барилгын инженер Д.Оюунтогтох /...../